

# Усан баптисм

Энэхүү материал нь усан баптисмийн утга учрыг танд ойлгуулж таныг Эзэн Есүсд дуулгавартайгаар усан баптисм хүртэхэд тань урамшуулах юм.

Усан баптисмийг хүртэхдээ тухайн хүнийг усанд булхуулаад гаргана. Энэ нь бидний зүрх сэтгэлд ямар нэгэн зүйл болсон бөгөөд тэр нь Бурханы Ариун Сүнсээр амьдардаг гэсэн билэгдэлтэй. Бурхан биднээс Есүсд итгэгч хүний хувьд үүнийг хүсдэг. Баптисм нь биднийг нүгэл болон үхлээс аврадаггүй гэдгийг бид энэхүү хичээлээр цааш үзэх болно. Харин зөвхөн Есүс л биднийг хуучин амьдралаас аварч шинэ амьдрал уруу хөтлөн дагуулж мөнхийн амийг өгдөг. Усан баптисм нь бусдад харуулсан билэг тэмдгийн чанартай ба хуримын бөгж гэрлэлтийг сануулах үүрэгтэй адил усан баптисм нь бидний авралын сануулга юм.

Эхлээд сүнслэг баптисмийн талаар суралцацгаая.

## Хэсэг 1

### Дотоод буюу Сүнслэг баптисм гэж юу вэ?

Сүнслэг баптисм гэдэг нь Бурханы өгсөн амьдралд шинээр төрөн амьдрах гэсэн үг. Энэ нь Бурханы бидэнд төлөвлөсөн амьдралын эхлэл юм. Бурхан бидний зүрх сэтгэлийг Өөрөөрөө мөн Өөрт байдаг зан чанараараа дүүргэдэгээр бүтээсэн нь Бурханы гайхалтай ажил юм. Энэ нь хатаж цангасан хөрс газарт бороо орох, өлссөн нэгэнд талх мэт адил бөгөөд энэ нь тэр чигээрээ Есүс Христ бидний зүрх сэтгэл, амь амьдралд Өөрийн Ариун Сүнсээр орох тухай юм. Гэхдээ энэ нь хүний нүдэнд харагдахгүй.

Элч Паул хэлэхдээ: “4Та нар өөрсдийнхөө дуудлагын нэг найдвар дотор дуудагдсаны адил нэг бие, нэг Сүнс, 5нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм бнэг Бурхан байна. Тэр бол бүгийн Эцэг бөгөөд бүгдийн дээр бүгдээр дамжуулан бүгдийн дотор байдаг.” (Ефес 4:4-6). Дотогшоогоо чиглэсэн сүнслэг баптисм гэж байдаг. Энэ нь Ариун Сүнс дэхь дахин төрөлтийн сүнслэг бодит байдал бөгөөд энэ нь биднийг Бурхан дахь шинэ амьдралд авчирдаг. Усан баптисм нь гадаад бөгөөд дотоод баптисмийн үзэгдэх бэлэг тэмдэг юм.

Сүнсний баптисм нь энгийн бөгөөд агуу зүйл юм. Библи дээр баптисм өөр янзаар ч бас хэлсэн байдаг. Жишээ нь: дахин төрөлт, аврал, шинэчлэгдэх гэх мэт. Бид Сүнсээр баптисм хүртэхэд юу болдог талаар Библи ингэж тайлбарласан байна.

Учир нь Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. (Колосай 1:13)

Бид үхлийн эрх мэдлээс аврагдаж, зөвийг үйлдэх эрх чөлөөний амьдралыг эхлүүлдэг. (Ром 6:5-14)

Бид сүнсэн дэх үхлээс аврагдаж Есүс доторх шинэ амьдрал эхлүүлсэн. (Иохан 5:24)

Тэр цагаас хойш Ариун сүнс хүний биед орж амьдарна. (Ром 8:9-11; Тит 3:5-6)

Бид Ариун Сүнсээр дахин төрсөн бөгөөд одоо Бурханы охид хөвгүүд болсон. (Иохан 3:3-8, Ром 8:14-17) Бид бол Есүс дотор шинэ бүтээл юм. (2 Коринт 5:17)

Бид Есүстэй нэгдсэн бөгөөд Түүнтэй хамт бүтээгдсэн. (Иохан 17:20-23, Галат 3:28)

Цаг хугацааны хувьд ч, чанарын хувьд ч мөнх амьдарч болох тэрхүү цоо шинэ амьдрал, Мөнх амьдралыг Есүстэй хамт туулахаар бид сүнсний хувьд хуучин амьдардаг байсан дадал зуршилаа орхидог. Яагаад гэвэл тэнгэрийн улс дахь хаан ширээндээ залран суугаа Есүс, Түүний үхэл, дахин амилалтын төлөө бид Есүстэй хамт усан баталгаа хүртэж байгаа юм. Бидний гэм нүгэлтэй байдал загалмай дээр цовдлогдон харин гайхамшигт байдлын оролцогч болж байгаа юм. (Ром 6:3-6; Иохан 10:10; Колоссай 2:11-13, 2 Петер 1:3-4)

Зүрхэн дэх чулуугаа авч хаяж харин оронд нь шинэ зүрх сэтгэл болох сүсийн зүрх сэтгэлийг хүлээн авагтун. (Езекиел 36:26-27).

Бидний зүрх итгэлээр ариутгагдсан (Үйлс 15:8-9)

Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн. (Ефес 1:3) Одоо бидний амьдрал бол эдгээр ивээлийг олж нээх илрүүлэх, мөн эдгээрийн хэрхэн тогтоохыг сурах тухай юм. Бидэнд Бурханы гайхамшигт хүч чадал, эрх мэдэл, ивээлтэй холбогдох холбоос байгаа бөгөөд Түүний өмнөөс хэрхэн ашиглагдахыг сурах чадвартай болсон. (Ефес 1:17-21)

Ариун Сүнсээр бидэнд өгөгдсөн онцгой Сүнслэг бэлэг болох зөгнөх, заах, зохион байгуулах, эсвэл анага, эдгээх зэргээс өөртөө байгааг нээх илрүүлж сүм чуулганы болон дэлхийн төлөө гэсэн зорилгоор хэрэглэх хэрэгтэй. (1 Коринт 12:4-11, Ром 12:6-8)

Дэлхийн хаана ч оршин байгаа нь хамаагүй бүх итгэгчдээс бүрддэг Есүсийн бие, Түүний сүм чуулган болохын тулд бид нэг Сүнсээр усан баталгаа хүртдэг. (1 Коринт 12:12-13; Иохан 15:1-8)



# Асуултууд

1. Explain in your own words the difference between spiritual and water baptism?

2. Explain in your own words what happens when we receive the Holy Spirit.

3. What new things have you learned in this first session?

# 2-р Хичээл

**Бид сүнсний баптизмыг хэрхэн хүлээж авдаг вэ? Бид Ариун Сүнсээр хэрхэн дахин төрөх вэ?**

Дэлхийг бүтээсэн Бурханы зорилго нь Түүнтэй үүрд хамт амьдрах сайн найзуудаа олох юм. Бидний төрж өсдөг, мөн биднийг аврах Есүсийн сайн мэдээг сонсоод хүлээн авах боломжтой энэ дэлхий нь түр зуурынх юм.

**Бурханы Төлөвлөгөө:** Есүс "Бид тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм" гэв (Иохан 10:10).

Хүн Бурханы ариун байдалд бүтээгдсэн боловч өөрсдийн хүслээрээ Бурханыг үл дагсан учраас энэ ариун байдлаас унасан юм. Хүний мөн чанар өөрчлөгдөж гэм нүгэлтэй, ёс зүйгүй болж, Бурханаас салгагдсан юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүгд энэ гэмт, Бурханаас тусгаарлагдсан байдлаас төрдөг учраас Бурханы хуульд байх ёстой ариун байдал тэдний дотор огт байдаггүй бөгөөд төрөлхөөсөө бузар муу ба гэм нүгэл үрүү хэвийдэг байна. Хүн Бурхан уруу эргэхгүй л бол Бурханы шудрага, үнэн шүүлтэнд ордог ба энэ шүүлт нь биднийг Бурханаас үүрд салгаж, мөнхийн үхлийг авчирдаг юм. Хүмүүс гэм нүгэлт учраас Бурхан тэдний дотор амьдрахгүй юм. Бурхан тэдний дотор амьдардаггүй учраас хүмүүсийн зүрхэнд их шаналал, хоосон чанар, ба ганцаардал байдаг юм.

**Хүн бол гэм нүгэлт:** "Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй" (Ром 3:23)

**Хүн Бурханаас салгагдсан:** "Учир нь нүглийн хөлс бол үхэл" (Бурханаас сүнсээр салгагдсан байдал) (Ром 6:23).

Гэвч Бурхан бидэн маш их хайртай. Бурханы Хүү болох Есүс Христ бол хүнийг гэм нүгэл ба Бурханаас салгагдсан байдлаас аварч чадах цор ганц аврагч юм. Есүсийг Аав нь илгээсэн ба Тэр өөрийн хүслээр хүн мөн чанартай ч гэм нүгэлгүй хүн болсон юм. Тэр Өөрийн төгс дуулгавартай байдлаараа Бурханы Хуулийг дээдэлсэн ба загалмай дээрх үхлээрээ бидний гэм нүглийн үнийг Өөрийн биеэр төлсөн юм. Тэр биеэрээ үхлээс амилсан ба одоо тэнгэр дэх Эцгийнхээ баруун гарын суудалд заларч, бүгдийг захирч байгаа.

**Бурханы хайр:** "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, хариан мөнх амьтай болох юм" (Иохан 3:16).

**Есүс бол Бурханд хүрэх цорын ганц зам:** Есүс, "Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй" гэв (Иохан 14:6).

**Тэр бидний оронд үхсэн:** "Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм" (Ром 5:8).

**Есүс үхлээс дахин амилсан:** "Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ. Тэр Кефт, дараа нь өнөөх арван хоёрт үзэгдэв. Үүний дараа Тэр таван зуу гаруй ах дүү нарт нэг мөчид үзэгдсэн ... (1 Коринт 15:3-6).

Есүс Өөрийн цусаа бидний төлөө урсгасан бөгөөд ингэснээр Түүнд итгэгч бүр гэм нүглээ цагаатгуулж болох юм. Бид өөрсдийн хийсэн сайн үйлсээрээ зөвтгөгддөггүй юм. Бид зөвхөн өөрсдийн Есүст итгэх итгэлээрээ л зөвтгөгддөг. Есүсийн зөвт байдал нь Бурханаас бидэнд үнэгүй өгөгддөг ба энэ нь биднийг Бурхантай эвлэрүүлж, Түүнийг тааллыг авчирдаг.

**Сайн үйлсээр бус итгэлээр аврагддаг:** "Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно. Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн" (Ефес 2:8-9).

### Би хэрхэн дахин төрөх вэ?

Та дахин бүхнийг эхлэхэд бэлэн үү? Та цоо шинэ эхлэл хийхийг үнэхээр хүсэж байна уу? Өөрсдийн зүрхэндээ өөрийгөө арай өөр байсан ч болоосой гэж хүсдэггүй хүн цөөн байдаг. Та амьдралаа дахин шинээр эхэлж амьрахыг үнэхээр хүсэж байсан удаатай юу? Тэгвэл яг одоо танд энэ боломж ирж байна. Энэ мөчид та Бурханы хийгээсэй гэсэн зүйлийг хийх хүч чадалтай гэдэг баталгааг дотроо хүлээн аваарай. Зөвхөн итгэ, тэгвэл Бурхан гайхамшгийг хийнэ. Энэ хүч нь итгэл ба итгэл нь өөрийн байгаа бүх л байдлаараа Бурханд шийдвэрт хариу өгөхийг хэлж байгаа юм. Яг одоо Бурханд хариулаарай.

Бурханы хаанчлалд орохын тулд хүн бүр Ариун Сүнсээр дахин төрөх ёстой юм. Зөвтгөлийг Бурхан бидний **төлөө** хийдэг; дахин төрөлтийг Бурхан бидний **дотор** хийдэг юм. Зөвтгөл нь Бурхан бид хоёрын **харилцааг** дайснаас найз уруу өөрчилдөг; шинэ төрөлт нь бидний **дотоод мөн чанарыг** гэмт хүнээс Христ доторх шинэ хүн болгон өөрчилдөг. Зөвтгөл нь гэрийн **уучлал**; шинэ төрөлт нь **гэмийн хүчийг нураагч** юм.

Сэтгэлийн гүний хүслийн дагуу тодорхой бай:

1. Өнгөрсөнөөс бүрмөсөн эргэ – Марк 1:15; Лук 13:3; Үйлс 3:19
2. Бурханы Хүү Есүс Христэд бүх зүрхээрээ итгэ – Марк 1:15; Иохан 3:16
3. Өөрийн дотоод сэтгэлд түүнийг бүрэн хүлээн авч Түүнийг өөрийн Аврагч, Эзэнээр хүлээн ав – Лук 11:13

Энэхүү нэгдэлийн үйлсийг Бурхан таниас шаарддаг юм. Тэгээд Бурхан сүнсээрээ таныг Өөрийн гэр бүлд дахин төрүүдэг. Ингэж л та дахин төрж чадна. Тэр цагаас хойш та өөрийн хуучин амьдралаараа амьдрахаар дахин эргэх ёсгүй юм. Та шинэ

амьтай болохын тулд хуучин амьдралаасаа хагацах ёстойг ойлгох хэрэгтэй. Одооноос Есүс таны дотор амьдарч, таниар дамжуулан Эцгийн хүслийг гүйцэлдүүлэх болно. Энэ бол Бурханы танд өгөх шинэ, мөнхийн амьдрал юм.



1. Хүн дахин төрөхөөсөө өмнө Бурханаас салгагдсан байдаг гол шалтгаануудыг тайлбарлана уу.

2. Ариун Сүнсээр дахин төрөх гэдэг нь ямар утгатайг өөрийн үгээр тайлбарлана уу.

3. Та Ариун Сүнсийг хүлээн авсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй ярь, хэрэв үгүй бол Ариун Сүнсийг хүлээн авахад танд юу саад болж байгааг ярина уу.

# 3-р Жицээл

## Усан доторх усан баптисмт гэж юу вэ?

Усан баптисм нь харагдахуйц бас бодит юм. Усан баптисм нь тухайн шинэ Христчин хүний дотор бий болсон үл харагдуйц бодит байдлыг бэлэгдэн түүнийг усанд оруулдаг юм. Бид Сүнсээр дахин төрснийхөө дараахан усан баптисм хүртэж болно. Усан баптисм дараах хэд хэдэн зүйлийг бэлэгддэг. Үүнд:

- Бид гэмээс ариусгагдсан. Усан дах баптисм нь гэмтний гэмээс ариусгагдсаны бэлэгдэл. Ус бидний биеийг хир буртгаас цэвэрлэдэгтэй адил Ариун Сүнс бидний зүрхийг бүх л сүнсний гэм нүглээс цэвэрлэдэг (Үйлс 22:16).
- Бид Христийн үхэл, дахин амилалт уруу нь баптисм хүрдэг. Бид дахин төрөх үед бид Христ уруу сүнсээр баптисм хүрдэг ба Христ үхсэн шиг бид Түүнтэй үхдэг мөн Тэр оршуулагдсан шиг бид Түүнтэй хамт оршуулагдаж, мөн Тэр үхлээс амилуулагдсан шиг бид бас шинэ амьдрал уруу үхлээс Түүнтэй хамт амилуулагдсан (Ром 6:3-7; Ефес 2: 4-7, Колоссай 2: 11-13). Үл харагдах энэ баптисмыг усан баптисм нь дүрсэлдэг юм (Галат 3:27). Бид амьд бөгөөд бид шинэ амьтай, Христ доторх шинэ бүтээл юм (2 Коринт 5:17). Уснаас гарч ирж байгаа нь булшнаас дахин амилж байгаагийн дүрслэл юм.
- Бид Сүнсний амьдралд орж байгаа. Сүнсийг заримдаа усаар дүрслэсэн байдаг (Иохан7:37-39). Түүнчлэн бидний бие усанд булхагдаж байгаа нь бидний бие амьд, эрх чөлөөт, хүчит, гаймамшигт Сүнсний амьдралд булхагдаж буйг харуулдаг. Бидний бие ус уруу орж байгаа нь бид Христийн Сүнсний амьдрал уруу нь бүхлээрээ баптисм хүртэж буйг дүрслэж байна.
- Усан баптисм нь бидний бие Христийн бие болох Сүмийн нэг хэсэг болж буйг харуулдаг (Ефес 4:3-6; 1 Коринт 12:12-13).

## Бид хэрхэн баптисм хүртэх хэрэгтэй вэ?

Христчин хүмүүс баптисмыг хэд хэдэн янзаар хийдэг. Христ доторх сүнслэг баптисмыг усанд булхах баптисм илүү тод илэрхийлдэгт бид итгэдэг. Үүнд итгэх хэд хэдэн шалтгаан байна:

Нэгдүгээрт, Грек үг ΒΑΡΤΙΣΜΟС нь ямар нэг зүйлийг усанд “шумбах, дүрэх, булхах” гэсэн утгатай. Энэ үгийн утгыг эртний Грекийн Библи ба Библиес гадуурхи уран зохиолд ашигласан байдаг. Уг үг нь хувцасийг өнгөнд оруулах, ховоогоор худгаас ус авах, завь живэх гэх мэт утгаар ашиглагдсан байдаг. Энэ үг нь асгах (ΕΚΣΗΘΕΙ) цацах (ΡΑΝΤΙΖΩ) гэсэн үгнүүдээс өөр байдаг.

Хоёрдугаарт, “булхах” гэсэн энэ үг Шинэ Гэрээний түүхүүдэд гардаг (Марк 1:5). Марк хэлэхдээ хүмүүс Иохан уруу ирж Иордан голд баптисм хүртсэн гэсэн байдаг. “Тэр голын уснаас гарч ирсэн” (Марк 1:10). Иохан, Есүс хоёр гол уруу ороод гарч ирж байгаа нь зөвхөн усаар шавшиж баптисм хүртээгүйг харуулж байна. Хэрэв усаар шавшиж баптисм хүртэж байсан бол гол уруу орох шаардлагагүй байх байсан. Өөр нэгэн хэсгээс баптисм Иохан Салимийн ойролцоо ус ихтэй учраас Аенонд баптисм хүртээсэн тухай гардаг (Иохан 3:23). Ус цацаж баптисм хүртээхэд их ус хэрэггүй харин булхаж баптисм хүртээхэд их ус хэрэгтэй юм (Үйлс 8:36-39). Библи дэх баптисм бүрийг усанд булхаж хийсэн байдаг.

Гуравдугаарт, Христийн үхэл, оршуулга, дахин амилалтанд нэгдэж буйг усанд булхалт нь сайн дүрсэлж харуулдаг. Паул Колоссайн хүмүүст хандаж тэд “баптисм дотор Түүнтэй хамт оршуулагдсан. Түүнийг үхэгдээс амилуулсан Бурханы үлсэд итгэсэн итгэлээр баптисм дотор та нар бас Түүнтэй хамт амилуулагдсан” гэж хэлсэн. (Колоссай 2:12). Энэхүү үнэн нь усан булхсан баптисм дотор илүү их илэрхийлэгддэг. Усан доор орох үе нь булшин дотор орж, Христтэй хамт оршуулагдсаныг илэрхийлдэг. Уснаас гарч ирж ирэх үе нь шинэ амьдрал уруу Христтэй хамт амилуулагдсаныг харуулж байгаа юм (Ром 6:3-4). Усаар шавших эсвэл асгаж баптисм хүртээх нь эдгээр зураглалыг харуулдаггүй.

Зарим үед эрүүл мэндийн шалтгааны улмаас усан булхаж орж чадахгүй хүмүүс байдаг. Энэ үед тухайн хүнийг боломжтой хэрээр нь норгож баптисм хүртээдэг. Ямар ч байсан бид Шинэ Гэрээнд гарч буй жишээг аль болох дагах хэрэгтэй.



1. Та усан ба сүнслэг баптисмийн утгыг товчлон хэлнэ үү? Энэ баптисмууд нь хоорондоо юугаараа ялгаатай вэ?

2. Усан баптисмийн талаар Бурхан танд юуг заасан бэ?

3. Та Христтэй хамт цовдлогдох, оршуулагдах, дахин амилагдах гэдэг нь юу болохийг өөрийн үгээр хэлнэ үү?

4. Сүнслэг баптисм дотор Христтэй хамт цовдлогдон, оршуулагдан, амилуулагдахийг усан доторхи баптисм нь хэрхэн харуулдаг вэ?

# 4-р Хичээл

## Яагаад баптисм гэж?

Хэрэв баптисм нь авралын дотоод бодит чанарын гадаад бэлэгдэл л юм бол яагаад хүмүүс баптисм хүртэх ёстой гэж?

### 1. Есүсийн гаргасан үлгэр жишээг дагах гэж

Тэр өдрүүдэд Есүс Галилын Назар хотоос ирж, Иордан голд Иоханаас баптисм хүртжээ. Марк 1:9. Лук 3:21-22, Иохан 1:29-34.

### 2. Есүс тушаасан учраас

Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав. (Матай 28:19-20). Есүсийг дагахаар шийдсэн хүмүүст баптисм дуулгавартай байдал юм. Есүс хэлэхдээ “хэрэв хэн нэгэн нь Намайг хайрлавал, тэр хүн Миний үгийг сахина” (Иохан 14:23) гэсэн учраас баптисм нь бидний хийх ёстой үүрэг бус харин Эзэндээ харуулах бидний хайрын үйлдэл юм.

### 3. Анхны цуглаанд баптисм хүртээдэг байсан ба элч нар ч үүнийг тушаасан.

- Пентекостийн өдөр - Үйлс 2:38-41
- Самари дахь эрэгтэй эмэгтэй хүмүүс - Үйлс 8:12-13
- Самарчууд - Үйлс 8:12-17
- Етопийн тайган - Үйлс 8:35-39
- Саул - Үйлс 9:18
- Корнелис ба түүний гэр бүл - Үйлс 10:44-48
- Филиппийн шоронгийн хуяг - Acts 16:33
- Ефес дэхь хүмүүс - Үйлс 19:1-7

### 4. Баптисм нь бидний жинхэнэ итгэгч болсоныг харуулдаг.

“коринтчуудаас олон хүн үгийг сонсоод итгэж, баптисм хүртэцгээж байлаа” Үйлс 18:8. Баптисм нь гэр бүл, найз нөхдөд маань бидний Есүс Христэд итгэлийн гэрч болдог тул хүмүүс Христчин гэдгийг тань мартажгүй. Баптисмд ирж буй үл итгэгч хүмүүс сайн мэдээг сонсох боломжтой болох юм. Бид Есүс Христэд итгэсэнээр Бурханы хаанчлалд орж байгааг баптисм бидэнд гэрчилдэг. Ямар нэгэн үл харагдах зүйл бидэнд тохиосныг харуулах биет гэрчлэл.

## Торч цуглаанд усан баптисмыг хэрхэн хүртээх вэ?

Усан баталгаа нь олон нийтэд бидний дотоод бодит байдлын баталгаа болдог учраас итгэсэн ба итгээгүй хүмүүсийг бас урамшуулах зорилгоор баптисмийг бүтэн сайны цуглааныхаа нэг хэсэг болгон тэмдгэлдэг. Усан баптисмийг олон хүн цугласан үед, цуглааны ахлагч нар хийнэ.

Торч цуглааны усан баптисм хүртэхийг хүссэн хүмүүс баптисмын хичээлд заавал хамрагдана. Дөрвөн хичээлийн дор хаяж гуравт нь суусан байх ёстой. Хичээлд суусны дараа цуглааны ахлагчид тухайн хүн баптисм хүртэхэд бэлэн эсэхийг шийднэ.

## Усан баптисмдаа та юуг бэлдэх ёстой вэ?

• Залбираарай: Бурханаас зүрх сэтгэлийг чинь бэлдээсэй хэмээн залбираарай. Цэвэр зүрх, саруул ухаан, даруу сэтгэлээр Эзэнтэй зөв харилцаатай байгаагаа шалгаарай. Баптисмын үйл ажилгаанд урьж буй хүмүүс тань Бурханыг таньж мэдээсэй хэмээн залбираарай.

• Богино хэмжээний гэрчлэл бэлдээрэй– Ром 10:9

1. Есүстэй уулзахаас өмнөх үеийн амьдрал, хэрхэн Христчин болсон, итгэснээс хойш юу болсон талаар хүмүүст яриарай.
2. Гэрчлэл бол бусад хүмүүс юм уу эсвэл Библийн сургаалийн талаар биш бөгөөд зөвхөн таны амьдрал болон танд юу тохиолдсон тухай ярих зүйлс юм.
3. Хэрхэн гэм нүглээ гэмшиж, хэрхэн Түүнд уучлалын төлөө итгэж мөн хэрхэн Түүнийг өөрийн Эзэн Аврагчаар зүрх сэтгэл, амьдралдаа хүлээн зөвшөөрсөнөө тайлбарлаарай.
4. Гэрчлэл бичихэд чинь туслах нэг хүнийг цуглаанаасаа сонгож болно.

• Эрт ирээрэй. Баптисмын дараа ус арчих алчуур болон солих хувцас авчраарай. Норох үед нэвт харагдах хувцас битгий өмсөөрэй.

## Баптисм хүртэх ёслол хэрхэн хийгдэх вэ?

Баптисм хүртэх цаг болоход ахлагч нарын нэг нь урагшаа гарах цаг болсоныг хүн бүрт сануулна.

Таны ус уруу орох ээлж болоход туслахаар хоёр ахлагч байх болно.

Ахлагч нараас нэг юм уу, хоёр хүн үг хэлээд, та товчхон гэрчлэл хуваалцана. Ахлагч нар залбирч өгөөд баптисм хүртээнэ.

Та гараа энгэртээ зөрүүлж хүсвэл хамраа чимхэж болно. Туслаж байгаа ахлагч нар таныг ар талаар тань ус уруу оруулан, бүрэн булхсаны дараа татан гаргана.

Таныг уснаас гарч ирэхэд, итгэлийн амьдралдаа нэг чухал алхам хийсний тань гэрч болсон чуулганы тань гэр бүл алга ташин баяр хүргэнэ.



1. Танд баптисмын талаар өөр асуулт байгаа юу? Байгаа бол доор тэмдэглэнэ үү.

2. Та усаар баптисм хүртэхэд бэлэн үү?

3. Дээрх зааврын дагуу өөрийн гэрчлэлийг бичээрэй. Эхлээд өөрөө бичих гээд үзээрэй. Бичиж дуусгаад ахлагч нар эсвэл найзуудынхаа нэгнээр уншуулан саналыг нь аваарай. Ийнхүү зассанаар та баптисм хүртэх өдрөө хуваалцахад бэлэн байх юм.